

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМ БОЛОН БОРОО ГОУЛД ХХК ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Хамтын ажиллагааны тухай энэхүү гэрээг нэг талаас Сэлэнгэ аймгийн Мандал сум, түүнийг төлөөлж тус сумын Засаг дарга Н. Лхагвадорж (цаашид "Нутгийн захиргаа" гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бороо Гоулд" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Э. Дөлгөөн (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 03 дугаар сарын 21-ны өдөр Мандал суманд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

"Бороо Гоулд" ХХК нь Сэлэнгэ аймгийн Баянгол сум болон Мандал сумын нутагт орших Бороогийн алтны үндсэн орд, Төв аймгийн Борнуур сум болон Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Улаанбулагийн алтны үндсэн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч мөн болно. Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Талууд дараах зорилгоор энэхүү Гэрээг байгуулж байна. Үүнд:

- 1.1. Энэхүү гэрээтэй холбоотой харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, олон улсын гэрээгээр зохицуулна.
- 1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжин ажиллахад Талууд хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.3. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Талууд хууль дээдлэх, тэгш эрх, шударга ёс, харилцан хүндэтгэх, ил тод байх, сайн дурын үндсэн дээр гэрээний үүргээ биелүүлэх зарчмуудыг баримтлан ажиллана.

Хоёр. Хамтын ажиллагааны зарчим

Энэхүү гэрээний хүрээнд Талууд хамтран ажиллахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 2.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах;
- 2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, хариуцлагатай биелүүлэх;
- 2.3. Төслийн үйл ажиллагаатай холбоотой нөгөө Талынхаа хүсэлт шаардлагыг хүлээн авч цаг тухайд нь шийдвэрлэх;
- 2.4. Бие биеийнхээ ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, хуулийг дээдлэх.

Гурав. Нутгийн захиргааны эрх, үүрэг

Энэхүү гэрээний хүрээнд Нутгийн захиргаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 3.1. Сумын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;
- 3.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар иргэдэд улирал тутам үнэн бодит мэдээлэл өгч, саналыг нь авах;
- 3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргэж, ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;
- 3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлыг батлагдсан үнэлгээ, төлөвлөгөөний дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавих, хамтран ажиллах;
- 3.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх;
- 3.6. Шаардлагатай тохиолдолд Тусгай зөвшөөрөл эзэмшигчид эмнэлэг, онцгой байдал, цагдаагийн үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн үйл ажиллагаагаа хэвийн бөгөөд тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

Энэхүү гэрээний хүрээнд Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 4.1. Сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар ЗДТГ-тай хамтран ажиллаж, шаардлагатай ажлын байр болон тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;
- 4.2. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, сумын иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;
- 4.3. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар сумын иргэдэд тогтмол буюу улирал бүр мэдээлэл өгч байх /сонин, сэтгүүл/;
- 4.4. Ажиллах хүч сонгохдоо, мөн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа бусад адил төрлийн бараа үйлчилгээтэй өрсөлдөхүйц бараа үйлчилгээ бүхий, тус суманд бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгохоор зорьж ажиллах;
- 4.5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г чанартай биелүүлж ажиллах. Үүнд:
 - БОМТ, түүний хэрэгжилтийг орон нутгийн иргэдийн төлөөлөлд тайлагнах, иргэдийн төлөөллийг уурхайн талбайд хүлээн авч танилцуулах;
 - Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг орон нутгийн иргэдийн төлөөлөлд газар дээр дээр нь танилцуулах, үнэлүүлэх;
 - Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулах;
 - Орон нутгийн ЕБС-иудад экологийн мэдлэг олгох сэдэвчилсэн, албан бус сургалт зохион байгуулах.

4.6. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр суманд техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний, санхүүгийн болон бусад материаллаг тусалцааг өөрийн нөөц бололцооны хэмжээнд үзүүлэх;

4.7. Байнгын, улирлын болон түр ажлын байранд Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, компани тухайн ажлын шаардлагыг хангасан гэж үзсэн орон нутгийн иргэдээс сонгож ажиллуулахыг эрмэлзэнэ.

Тав. Хамтран хэрэгжүүлэх ажлын чиглэлүүд

Талууд дараах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов.

5.1. Компани нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр 40,000,000.00 (дөчөн сая) төгрөгийн санхүүжилт олгоно. Төсөл, хөтөлбөрийг сонгох, хяналт тавих ажлыг Хамтын ажиллагааны хороо (цаашид "Хороо" гэх) хэрэгжүүлнэ. Талууд дараах чиглэлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр харилцан тохиролцов. Үүнд:

5.1.1. Дэд бүтцийн хөгжлийг дэмжих (зам засвар, замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч, камержуулалт гэх мэт);

5.1.2. Нийгмийн суурь үйлчилгээний хөгжлийг дэмжих (эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн сургалт);

5.1.3. Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн хүсэлтээр Бороогийн уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцах аяллыг аюулгүй ажиллагааг хангах үүднээс нэг удаад 20-иос илүүгүй хүнд зориулан зохион байгуулна.

5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн нийгэм, эдийн засгийг дэмжих бусад төсөл, хөтөлбөр болон уламжлал болсон арга хэмжээг сайн дурын үндсэн дээр хамтран хэрэгжүүлэхэд жил бүр 60,000,000 (жаран сая) хүртэлх төгрөгийн санхүүжилтийг гаргаж болно. Үүнд дараах үйл ажиллагаа хамаарч болно.

5.3.1. Тэмдэглэлт баярыг хамтран зохион байгуулах, оролцох;

5.3.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийг дэмжиж ажиллах;

5.3.3. Соёл, спортын арга хэмжээг хамтран зохион байгуулах, дэмжих;

5.3.4. Урлаг, спортын өндөр амжилт гаргаж буй иргэдийг дэмжих;

5.3.5. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтран ажиллах, дэмжих;

5.3.6. Мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих;

5.3.7. Сургалт явуулах;

5.3.8. Хандив, тусламж үзүүлэх;

5.3.9. Сумын онцгой байдлын хэлтэстэй хамтран сургалт явуулж, мэдээлэл солилцох.

5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа сэргээж, алт олборлох болсон нөхцөлд Талууд хөрөнгө оруулалтын дүнг дахин хэлэлцэнэ.

Зургаа. Хамтын ажиллагааны хороо

6.1. Талууд гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг сонгох, түүний санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих зорилгоор Хамтын ажиллагааны хороо (цаашид "Хороо" гэх)-г Нутгийн захираа, Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулахаар тохиролцов.

6.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд орон нутгийн төлөөлөл 5 (үүнээс нэг буюу түүнээс дээш гишүүн нь нийтийн албанд ажилладаггүй иргэний төлөөлөл байна), Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөл 4 хүнтэйгээр байгуулагдана. Хорооны бүрэлдэхүүнд орох орон нутгийн төлөөллийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

6.3 Хорооны дүрмийг талууд боловсруулж, баталгаажуулсны үндсэн дээр Хороо үйл ажиллагаагаа эхлүүлнэ. Хорооны дүрэм, сонгон шалгаруулсан төсөл, хөтөлбөрийн жагсаалт нь энэхүү гэрээний хавсралт болно.

Долоо. Гэрээний хэрэгжилт

7.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор сумын иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбоотой баримт бичгийг гэрээг байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор талуудын цахим хуудсанд байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор тус аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын Дэд зөвлөлд хүргүүлнэ.

7.2. Талууд гэрээний тухайн оны биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

7.3. Талууд гэрээний тухайн оны биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Найм. Гэрээний хариуцлага

8.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь талууд хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

8.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Ес. Маргаан шийдвэрлэх тухай

9.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Арав. Гэрээ хүчин төгөлдөр болох

10.1. Энэхүү гэрээг 5 (тав) жилийн хугацаагаар байгуулав. Гэрээний хугацаанд Талууд жил бүр 12 дугаар сарын 20-ны дотор Гэрээний хэрэгжилтийг дүгнэнэ. Талууд гэрээний хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэсэн нөхцөлд дараа онд гэрээ анх

тохиролцсон нөхцөлөөр хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Талууд гэрээний хэрэгжилтийг дүгнээд шаардлагатай гэж үзвэл гэрээнд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.


10.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч Бороогийн болон Улаанбулагийн алтны үндсэн ордын тусгай зөвшөөрөлтэй талбайгаасаа алт олборлож, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь сэргэсэн нөхцөлд тухайн төслийн талаарх мэдээллийг орон нутагт танилцуулж, энэхүү гэрээний дагуу олгогдох санхүүжилтийн дүнг Талууд дахин хэлэлцэнэ.

10.3. Талууд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг Талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

10.5. Гэрээг англи, монгол хэлээр тус бүр 2 хувь үйлдэх бөгөөд талууд тус бүр нэг хувийг хадгална. Хоёр хувилбарын хооронд зөрөө гарвал Монгол эхийг баримтлахаар Талууд тохиролцов.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫГ БОРОО ГОУЛД ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:



СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА
НАЦАГДОРЖИЙН ЛХАГВАДОРЖ

БОРОО ГОУЛД ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЭРДЭНЭБААТАРЫН ДӨЛГӨӨН




**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМ БОЛОН "БОРООГОУЛД" ХХК-ИЙН ХООРОНД 2019
ОНЫ 3 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГЭРЭЭНИЙ "1" ДЭХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

Сэлэнгэ аймгийн Мандал сум /цаашид "Нутгийн захиргаа" гэх/ болон "Бороогоулд" ХХК /цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч", хамтад нь "Талууд" гэх/ нарын хооронд 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан "Хамтын ажиллагааны гэрээ" /цаашид "Гэрээ" гэх/-нд талууд Гэрээний 5.4, 10.2 дахь заалтуудыг үндэслэн дараах нэмэлт, өөрчлөлтийг харилцан тохиролцож 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр оруулав.

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн Бороогийн алтны шороон орд болон Улаанбулагийн алтны үндсэн ордыг ашиглах болсонтой холбоотойгоор Талууд Гэрээний дагуу олгогдох санхүүжилтийн дүнг дахин хэлэлцээд Гэрээний 5.1-д "40,000,000.00 (дөчин сая)" гэснийг "150,000,000." гэж, Гэрээний 5.3-т "60,000,000 (жаран сая) хүртэлх" гэснийг "60,000,000" гэж тус тус өөрчлөхөөр харилцан тохиролцов.
2. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг Гэрээний 5.4, 10.2 дахь заалтуудыг үндэслэн зөвхөн Гэрээний 5.1, 5.3 дахь заалтуудад заасан санхүүжилтийн дүнг нэмэгдүүлэн өөрчлөх зорилгоор оруулсан бөгөөд Гэрээний бусад бүх заалт цаашид хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.
3. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
4. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нутгийн захиргааг төлөөлж:



Н. ЛХАГВАДОРЖ
СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:



Э. ДӨЛГӨӨН
"БОРООГОУЛД" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Огноо:

Огноо: